

БАТЛАВ:  
САЙНЦАГААН СУМЫН ГХУСАЗЗ-ИЙН  
ДАРГА Б.ӨЛЗИЙБАЯР  
2018 оны 4 сарын 06-ны өдөр

**"ГЭМТ ХЭРЭГ ЗӨРЧИЛГҮЙ БАГ"  
АЯНЫ УДИРДАМЖ**

**Зорилго :** Гэр бүлийн хүчирхийлэл, орон байрны хулгайн гэмт хэрэг, болон зам тээврийн осол, ахуйн хүрээнд архидаг согтуурсны улмаас үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийн оролцоо идэвхи, санаачлагыг нэмэгдүүлэх тэдний хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд оршино.

**Хамрах хүрээ:** Сайнцагаан сумын төвийн 5 багийн дунд зохион байгуулагдана

**Хугацаа:** 2018 оны 04 сарын 09-ны өдрөөс 2018 оны 12-р сарын 15 хүртэл

**Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:**

1. "Гэмт хэрэг, зөрчилгүй баг" уриалга бүхий аяны цом, хавтсыг нэг багт ажлын 10 хоног аялуулна.
2. Цом дэвтрийг хүлээн авсан баг аяны нээлтийн үйл ажиллагааг багийнхаа хэмжээнд зохион байгуулан, аяны зорилгын хүрээнд тодорхой үр дүнтэй ажлуудыг багийн иргэдийн хамтын ажиллагаанд түшиглэн зохион байгуулна.
3. Аяны хүрээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг ГХУСАЗСЗөвлөл боловсруулан баталж бүрэн хэрэгжүүлж ажиллах
4. Орон байрны хулгайн гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдэх гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлсэн ажил арга хэмжээ зохион байгуулах
5. Гарч болзошгүй аюул, осол гэмтлээс урьдчилан сэргийлсэн ажил арга хэмжээг зохион байгуулах
6. Архи, тамхины хор уршиг, ахуйн хүрээнд архидаг согтуурах явдлаас урьдчилан сэргийлсэн ажил арга хэмжээг зохион байгуулах
7. Аяны хүрээнд хөршийн холбоо байгуулж, гудамж бүрт хэсгийн ахлагч томилох
8. Аяны хугацаанд иргэдийг эргүүлд гаргах ажлыг чанартай, тасралтгүй зохион байгуулах / эргүүлийн хуваарийг баталж хавсаргах /
9. Дээрх гэмт хэргүүдээс урьдчилан сэргийлсэн боршур, сэрэмжлүүлэг, шторк бэлтгэж олон нийтэд сурталчлах / тараасан материалыг авсан хүний гарын үсгээр баталгаажуулах/
10. Гудамжны гэрэлтүүлэг, гудамж бүрт хяналтын камер тавих ажлыг иргэдийн оролцоотой зохион байгуулах /одоо байгаа болон зохион байгуулсан ажлын хүрээнд ямар өөрчлөлт гарсан тухай зургаар үзүүлэх /
11. Баяр ёслол, тэмдэглэлт өдрүүдэд гудамж хороололд иргэдийн эргүүлийг тогтмол ажиллуулж цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах
12. Аяны хавтсанд зохион байгуулсан арга хэмжээний тайланг фото зургийн хамт хавсаргаж, цом хавтсыг хуваарийн дагуу дараагийн багт хүлээлгэн өгнө.

13. Аяны явцад зохион байгуулсан ажлынхаа талаар орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, багийнхаа Facebook болон цахим хуудсаар иргэд олон нийтэд сурталчлах, Сайнцагаан сумын ГХУСАЗЗ-ын пэйж хуудсанд байршуулах

**Аяныг дүгнэх:**

1. Уг аяныг 2 удаа зохион байгуулах бөгөөд 4,5-р сард эхний арга хэмжээг 9,10,11-р сард 2 дахь аяныг үргэлжлүүлэн зохион байгуулна.
2. Удирдамжинд заагдсан ажил, арга хэмжээ болон бусад санаачлан хэрэгжүүлсэн ажлын тайлан, холбогдох материалыг Сайнцагаан сумын ГХУСАЗЗөвлөл 2018 оны 12-р сарын 15-нд нэгтгэж гаргаж дүгнэнэ.

**Гарах үр дүн:**

1. Иргэдийн эрх зүйн мэдлэг дээшилнэ
2. Аюулгүй амар тайван орчин бүрдэнэ
3. Ахуйн хүрээнд архидан согтуурах явдал багасна
4. Тухайн багийн нутаг дэвсгэрт орон байрны хулгайн гэмт хэрэг буурах буюу бүртгэгдээгүй байх
5. Багийн гудамж хороолол, ойр орчимд гэрэлтүүлэг, хяналтын камер тавигдсан байна
6. Бусдын бие махбодид гэмтэл учруулах гэмт хэрэг үйлдэгдээгүй байх, уг гэмт хэрэг багийн хэмжээнд буурсан байх

**Анхаарах зүйл:**

Аяны удирдамжийн дагуу ажлыг зохион байгуулах бөгөөд багууд заасан хуваарийн дагуу Цом дэвтрийг дараагийн багт хугацаа алдалгүй хүргэж өгөхийг анхаарах шаардлагатай.

**Шагнал, урамшуулал:**

Сайнцагаан сумын "Гэмт хэрэг, зөрчилгүй баг" шалгаруулна.

Тэргүүн байр - /Өргөмжлөл, мөнгөн шагнал/  
Дэд байр - /Өргөмжлөл, мөнгөн шагнал /

**САЙНЦАГААН СУМЫН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ  
АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ**

**"ГЭМТ ХЭРЭГ ЗӨРЧИЛГҮЙ БАГ" аян**  
**зохион байгуулах ажлын хуваарь**

| № | Байгууллагын нэр | Аяны эхний үйл<br>ажиллагаа |                   | Аяны төгсгөлийн үйл<br>ажиллагаа |                   |
|---|------------------|-----------------------------|-------------------|----------------------------------|-------------------|
|   |                  | Эхлэх<br>хугацаа            | Дуусах<br>хугацаа | Эхлэх<br>хугацаа                 | Дуусах<br>хугацаа |
| 1 | Аравжих<br>баг   | 2018/04/09                  | 2018/04/20        | 2018/09/17                       | 2018/09/28        |
| 2 | Боржигон<br>баг  | 2018/04/23                  | 2018/05/04        | 2018/10/01                       | 2018/10/12        |
| 3 | Нарлаг<br>баг    | 2018/05/07                  | 2018/05/18        | 2018/10/15                       | 2018/10/26        |
| 4 | Мандал<br>баг    | 2018/05/21                  | 2018/06/01        | 2018/10/29                       | 2018/11/09        |
| 5 | Айраг<br>баг     | 2018/06/04                  | 2018/06/15        | 2018/11/12                       | 2018/11/23        |